

≡ УЙЛ ЯВДАЛ ≡

Ардын багш цол хүртэв

МУИС-ын ахмад багш нарын нэг, хэл бичгийн ухааны доктор, Монгол Улсын Төрийн соёрхолт, Гавьяат багш Ш.Чоймаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 2017.07.09-д Ардын багш цол хүртлээ.

Ш.Чоймаа нь 1951 онд Говь-Алтай аймгийн Шарга сумын нутаг Шар харгана хэмээх газар төржээ. 1971-1976 онд МУИС-ын Хэл бичгийн факультетэд суралцаж монгол хэл-уран зохиолын багш мэргэжил эзэмшсэн ба тэр үеэс тус сургуульдаа багш, тэнхимиин эрхлэгч, зөвлөх профессороор тасралтгүй ажилласан байна. Мөн 1980-1983, 1992-1995 онд Герман улсын Берлин хотын Гумбольдтын Их Сургуульд зочин профессороор уригдан ажиллажээ.

Тэрбээр “Монголын нууц товчоо, Лувсандаанзын Алтан товчын эхийн харьцуулсан судалгаа” сэдэвт бүтээлээр 2003 онд доктор (Ph.D), “Монгол түүхэн сурвалжийн эх бичгийн судалгаа” сэдэвт бүтээлээр 2004 онд доктор (Sc.D) зэрэг хамгаалсан ба 1996 онд МУИС-ын дэд профессор, 2011 онд профессор цол тус тус хүртжээ.

Монгол бичиг, түүхэн хэлзүй, орчин цагийн монгол хэл, төвд хэл, сурвалж судлал, Монголын нууц товчооны судлалын чиглэлээр олон арван ном, өгүүлэл хэвлүүлсэн ба монгол сурвалж судлал, монгол хэл бичиг, соёл судлалын чиглэлээр бичсэн өгүүллүүд нь “МУИС-ын профессорын өв” цувралд 2 ботиор хэвлэгдсэн байна.

МУИС-ын ахмад багш нарын нэг, хэл бичгийн ухааны доктор, Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн С.Дулам Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 2017.12.29-д Ардын багш цол хүртлээ.

С.Дулам нь 1950 онд Баянхонгор аймгийн Баянбулаг сумын нутаг Бүлээн гэдэг газар төржээ. 1968-73 онд МУИС-ийг монгол хэл-уран зохиолын багш мэргэжлээр төгссөн бөгөөд 1973 оноос МУИС-д багш, тэнхмийн эрхлэгч, зөвлөх профессороор 40 жил ажиллаж олон арван шавь бэлдсэн ба Кембрижийн их сургууль /1993/, Боннын их сургууль /1993, 1997, 2013-2014/, Парисын X их сургууль /1991,1994/, Страсбургийн их сургууль /1997, 2005/, Бээжингийн Төвийн үндэстний их сургууль /2003, 2010, 2012/, Ланчжуогийн Баруун хойтын үндэстний их сургууль /2008, 2009/, Францын Франсуа Раблэгийн нэрэмжит Турын их сургуульд /2012, 2014/, Италийн Ромын их сургуульд /2010, 2012/ тус тус уригдан лекц уншиж байв. Тэрбээр 1982 онд Москва хотноо Дорно дахин судлалын хүрээлэнд “Монгол домогзүйн дүр, утга зохиолын уламжлал” сэдвээр хэлбичгийн ухааны дэд эрдэмтний зэрэг, 1997 онд Буриадын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнд “Монгол аман зохиол, утга зохиол дахь бэлгэдэл зүйн тогтолцоо” сэдвээр шинжлэх ухааны докторын зэрэг тус тус хамгаалсан бөгөөд монгол домог зүй, бөө мөргөл, бэлгэдэл зүйн судалгааг эх орондоо шинээр үүсгэн хөгжүүлэхэд бүхий л хөдөлмөрөө зориулж явна.

* * *

* * *

Номын нээлт болов

МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнгээс “МУИС-ийн профессорын эрдмийн өв” цуврал бүтээлүүдийг эрхлэн гаргалаа. Уг цуврал бүтээлийн эхний дугааруудад монгол хэл бичгийн нэрт эрдэмтэн, профессор Д.Төмөртогоо, Ш.Чоймаа, Ц.Шагдарсүрэн, М.Базаррагчаа нарын эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган хэвлэгдэж нээлтээ хийлзэ.



Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, хэлшинжлэлийн ухааны доктор, профессор Мөнхжаргалын Базаррагчаагийн эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган 4 боть бүтээл “Монгол хэлний авиаалбар судлал”, “Монгол хэлний бүтээвэр судлал”, “Монгол хэлний үг судлал”, “Монгол хэлний өгүүлбэр судлал” номын нээлт 2017 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, хэлшинжлэлийн ухааны доктор, профессор, академич Д.Төмөртогоогийн эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган 2 боть бүтээл “Монгол хэлний түүхэн хэлшинжилэлийн судалгаа”, “Монгол хэл шинжилэлийн судалгааны түүхээс” номын нээлт 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр болов.

Мөн Монгол Улсын төрийн шагналт, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, хүмүүнлэгийн шинжлэх ухааны доктор, профессор Цэвэлийн Шагдарсүрэнгийн эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган 3 боть бүтээл “Монгол хэл шинжлэл алтай судлал”, “Нийгэм соёл, эхбичигийн судалгаа, угсаатны зүй”, “Судалгааны тэмдэглэл, нийтлэл, бодол эргэцүүлэл” номын нээлт 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр, Монгол Улсын төрийн шагналт, Ардын болон гавьяат багш, хэлшинжлэлийн ухааны доктор, профессор Шаравын Чоймаагийн эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган 2 боть бүтээл “Монгол сурвалж судлал”; “Монгол хэл, бичиг; соёл судлал” номын нээлт 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр тус тус болж өнгөрлөө.



* * *